



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2018.05.15 № 5/2342  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай


“Монгол Базальт” хаалттай ХК-ийн үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах хуваарилалтын төлөвлөгөөнд чиглэл өгөх тухай 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 04/65, 5 дугаар сарын 11-ний өдрийн 05/68 тоот албан бичигтэй танилцлаа.

Хорооны 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор “Монгол Базальт” хаалттай ХК-ийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 56,417,000 ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэж, бүртгүүлсэн хувьцааны 30 хувь буюу 16,925,100 ширхэг хувьцааг 380 төгрөгөөр олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн билээ.

Хорооны 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 169 дүгээр тогтоолын 3 дугаар хэсгээр “Монгол Базальт” хаалттай ХК-ийн 16,925,100 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар олон нийтэд нээлттэй арилжаалах”-ыг зөвшөөрсөн бөгөөд Хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд үнэт цаасыг бүртгэх шийдвэр гарч, анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө хөрөнгө оруулагчийн бүтцийг өөрчлөх шийдвэр гаргахгүй байхыг мэдэгдэж байна.

Хувийг: “Монголын хөрөнгийн бирж” ХК-д.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН ДАРГА



Б.ЛХАГВАСҮРЭН

004675



Брокер Дилер Андеррайтерийн Компани

2018 он 05 сарын 15 өдөр  
Дугаар № 05/80

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ-д

### Хуваарилалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай:

“Бумбат Алтай ҮЦК” ХХК нь “Монгол Базальт” ХК-н олон нийтэд үнэт цаасаа санал болгох ажлын үндсэн андеррайтераар ажиллаж байна. Уг ажлыг амжилттай зохион байгуулах хүрээнд “МХБ”-д 2018 оны 5 сарын 10 ны өдөр №04/66 дугаар албан бичгийн хавсралтаар “Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалтын төлөвлөгөө”-г хүргүүлсэн билээ. Гэвч уг хуваарилалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орох шаардлагатай болсныг энэхүү албан бичгээр мэдэгдэж байна.

“Монгол Базальт” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааны хуваарилалтыг төлөвлөгөөг “Санхүүгийн зохицуулах хороо” хянаж үзээд “Монгол Базальт” ХК-ны олон нийтэд санал болгож буй 16,925,100 ширхэг хувьцааг нийтэд санал болгохдоо хөрөнгө оруулагчдын бүтцийг өөрчлөх буюу хязгаарлалттай болон хязгаарлалтгүй гэж хуваахгүй байхыг мэдэгдсний дагуу бид СЗХ-ны шаардлагад нийцүүлж, дахин боловсруулсан хуваарилалтын төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд хөрөнгө оруулагчдыг дотор нь ангилахгүй, бүгдэд ижил нөхцөлөөр хуваарилах зарчимд суурилсан болно. Бидний эхний боловсруулсан төлөвлөгөөний дагуу стратегийн ангилалаар хөрөнгө оруулахаар төлөвлөж байсан хөрөнгө оруулагчид нь бусад бүх хөрөнгө оруулагчидтай ижил нөхцөлөөр захиалгаа өгч, хуваарилалтад орох болсныг мэдэгдье.

Хавсралт: 1/ Шинэчлэсэн хуваарилалтын төлөвлөгөө

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш.ЭНХМЭНД

41 тоот, 4-р хороо 496 байр  
Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг  
Монгол улс Утас: 99968989

E-майл: bumbatai\_21@yahoo.com

"Бумбат Алтай ҮЦК" ХХК батлав.

2027103  
П/ОН0230

## ҮНЭТ ЦААСНЫ ХУВААРИЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Базальт ХК нь олон нийтэд 16,925,100 ширхэг хувьцааг санал болгож 6.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьж байна.

Анхдагч зах зээлийн худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд дараах хүснэгтэд заасны дагуу хөрөнгө оруулагчдын тооноос хамааран харгалзах хэмжээг 100 хувь биелүүлж түүнээс дээш гарсан мөнгөн дүнд хувь тэнцүүлэн хуваарилна.

| Суурь хувиарлалт хийх Мөнгөн Дүн | Биелэх мөнгөн дүн                          | Хувь тэнцүүлэгдэх мөнгөн дүн | Биелэх мөнгөн дүн                                     |
|----------------------------------|--|------------------------------|---|
| 1.0 тэрбум төгрөг                | Нийт захиалга өгсөн хүний тооноос хамаарна | 5.4 тэрбум төгрөг            | Нийт захиалгын мөнгөн дүнд харьцуулж, хувь тэнцүүлнэ. |